

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

| | | | |
|---|-----------------------|---------------------|------------|
| Ярилцлага өгөгчийн нэр | Охины Шархүү | Дугаар | L250 |
| Оршин суугаа аймаг | Өмнөговь | Оршин суугаа сум | Сэврэй сум |
| Төрсөн газар | Сэврэй сум | Төрсөн он | 1926 |
| Ажил мэргэжил | Өндөр настан | | |
| Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд | Дуганы хурал | Сүм хийдийн дугаар | ӨГСВ 007 |
| Одоогийн сүм хийд | | Сүм хийдийн дугаар | |
| Ярилцлага авсан он сар өдөр | 2007 оны 6-р сарын 11 | Ярилцлага авсан хүн | Ц.Гантулга |

Өмнөговь аймгийн Сэврэй сумын Дуганы хурал

Гантулга: За энэ хүн бол Дуганы хийдийн ойролцоогоор нутаглаж байсан малчин гаралтай хүн юм байна.

Гантулга: За Шархүү гуай,

Шархүү: Өөв?

Гантулга: Та одоо бага байхдаа энэ таныг энэ ар хийдэд байсан гэж байна .Та тэгээд энэ Дуганы хийд , Хоолтын хийдийн байсан байдлын талаар товч яриад өгөхгүй юу, бид нарт. Өөрийнхөө үзэж харж байсныгаа?

Шархүү: За Дуган гол гэдэг бол нэлээн хэдэн шавар байшинтай тийм газар байсан юм. Тэрэн дээр бас нэг хорь гаруйхан гучаад лам нар байдаг байсан байх. Тэгээд тэрүүгээр юу байсан бэ гэхлээр зэрэг Шар Дунай гэж нэг Хятад хүн байсан.Тэгээд тэрүүгээр найман суваргыг тэр Дуганы хийдийн Лувсаншарав гэдэг лам бариулж байсныг нь нэг мүү мэдэх юм.

Гантулга: Аа тэр хүн бол яг барьж байхыг нь та мэдэх үү?

Шархүү: Мэднэ ээ.

Гантулга: Хэдтэй байсан, та тэгэхэд?

Шархүү: Аа бас л арван хэдтэй л байсан байх даа.

Гантулга: Аа зөв зөв.

Шархүү: Тэгэхэд бол тэр хятад бариад л байдаг байсан .Тэгж байгаад сүүлд нь нэг мэдэхэд л найман суварга гэдэг юм босчихсон л байсан.

Гантулга: Ганцаараа л бариад байсан үү?

Шархүү: Ганцаараа л бариад байсан. Тэр наана нь даадаг ламтай юм болохлээр. Тэгээд тэр хийдийн хамгийн хамба лам нь Гочоо маарамба гэдэг хүн байсан юм.Тэр Гочоо маарамба гэдэг хүн бол яахав дээ, их л том лам тэр үедээ л тэр хийдийн том лам гэж нэртэй маарамба хүн байсан. Маарамба гэж нэрлэдэг. Тэгээд амьтан хүн ч

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

их үзүүлдэг, судас шөрмөсөө бариулдаг .Тийм л хүн байсан. Энийг л мэдэж байна. За энэ Хоолтын төв гэдэг дээр бол урдүү цагт Маанийн хийд гэж байсан юм гэнэ лээ. Тэгэхэд бол тэр гамингийн үед л алга болсон юм гэнэ лээ. Тэрнээс хойш мэдэхгүй юм аа.Тэр Дуганы голын лам нарын томчууд бол том лам нар нь бол бараг нь сүүлдээ эсэргүү хэрэгт автагтаад тэгээд гол нь тэр Гочоо маарамба гэдэг татагдаад тэгээд явсан сурагтай байдаг. Нэлээн хэдэн лам нар байж байгаад одоо...

Гантулга: Тэр суварга бариулсан хүний тухай та ярьж өгөөч?

Шархүү: Тэр Лувсаншарав гэдэг үү?

Гантулга: Аан.

Шархүү: Тэр Лувсаншарав гэдэг бол суварга бариулчихаад тэгээд тэр хамгийн сүүлд нь үлдчихсэн тийм хүн байсан юм. Одоогоор бодох юм бол хаашаа юм бэ дээ, жаахан одоо юмтай, панз наймаа хийдэг хүн байсан юм уу даа. Тэр нэг тийм л хүн байж л дээ.Тэгээд өөрөө бас байшин хашаатай тийм хүн байсан юм.Тэгээд суварга бариулаад , тэр бусад лам нар татагдаад дууссан.Тэр Лувсаншарав гэдэг хүн эргэж ирсэн байгаа.Тэгээд хамгийн сүүлд баригдсан.Тэгээд нэг айлд очиж , айлын жасаа өмсөж суусан юм гэнэ лээ.Тэр Лувсаншарав. Тэгээд л шөнө үдэш болсон чинь нэг хоёр хүн ирсэн гэдэг байх аа.Энэ Овоотын отряд л гэдэг байсан юм.Тэндээс хоёр хүн ирээд л , барих гээд л ирдэг юм байна.Тэгээд л баригддаг юм байна, нөгөө айлд жасаагаа өмсч үдэш харанхуй болж.Тэгээд л нөгөө Лувсаншарав гэдэг хүн чинь яаж ч айлын хүнтэй хэл өгж чадсан юм. Дөмөгхөн тэмээ догшилчихоорой гэж хэлсэн юм гэнэ лээ.Тэгээд л айлын хүн нь тэмээ догшилчихсон.Нөгөө хоёр хүн үдэш шөнө болж Лувсаншаравыг чинь дуган луу гэр лүү нь аваад явдаг юм байна. Тэгээд л дуган луугаа яваад л дуганых нь тэнд нэг хэдэн хана байдаг юм л даа.Тэгээд л тэднийхээ нэгээр ороод л тэгсэн гэнэтхэн тэмээгээ ташуурдаад л пэс пас гээд л чимээгээр тэгээд л байхгүй.Тэгээд алдчихсан. Тэгээд байхгүй байж байгаад тэр лам энэ урагшаа урд хил явчихсан юм.

Гантулга: Аа мөн Өвөрмонгол руу?

Шархүү: Өвөрмонгол руу ячихсан юм гэнэ лээ.Тэгээд тэр лам буцаж энд ирээгүй л дээ. Тэгээд одоо хааччихсан юм бүү мэд.Тийм л түүхтэй юм ерөөсөө.

Гантулга: Одоо энэ Суваргын хурлын талаар бол юм мэдэхгүй юу, та?

Шархүү: Энэ талаар бол мэдэхгүй.

Гантулга: Та одоо энэ Дуган хурал, Хоолтын хурлын ойр орчмын байгаль ,одоо тийм уул зүүн талд нь тийм юм байдаг гээд газар усны нэрийг,нутгийнхны хэллэгээр урд нь тийм булаг байдаг ч гэдэг юм уу, Дуган хийдийн талаар ярьж өгөөч?

Шархүү:Дуган гэдэг чинь өөрөө тэндээ жаахан голтой, жаахан задгай устай тийм. Цагаан булаг гэж одоо тусгай Цагаан булаг гэж нэртэй тийм задгайтай.Тэгээд Дуганыхаа энчээ талд Өвгөн толгой гэж...

Гантулга: Хаахна талдаа?

Шархүү: Зүүн талдаа Өвгөн толгой гэж хад цохиотой.Өвгөн толгой нэртэй.Тэгээд тэр урд талд нь Эрдэнэлүнцаг гэж нэг уул байдаг юм.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гантулга: Эрдэнэхудаг аа?

Шархүү: Эрдэнэпунцаг.

Гантулга: Аа зөв зөв.

Шархүү: Тийм нэг уул байдаг юм.Тэр уулыг тахидаг байсан юм гэнэ лээ.Тэр лам нар...

Гантулга: Дуган хурлын лам нар?

Шархүү: Тийм, Дуган хурлын лам нар.

Гантулга: Тахилгынх нь тухай бол юм дуулаагүй юу?

Шархүү: Үгүй.

Гантулга: Аа тэгээд баруун талд нь ч гэдэг юм уу, ингээд тойроод хэлвэл?

Шархүү: Аа тэгээд тойроод хэлвэл яахав дээ, тэр ард руугаа болвол Бүрдний гол л гэж байна. Баруун тийшээ яваад Түвшин Хайрхан гэж нэг уул бий. Зүүн тийшээгээ жаахан явахаар Эрдэнэбулаг гээд хоёр худаг байна.Тэгээд наашаагаа ,зүүн урд талаадаа гарахлээр зэрэг Баян бор нуур залгаж байгаа юм л даа.Тэгээд наашаа явахлээр зэрэг Ноён нурууны зүүн үзүүр залгаж Хонгорын голын эх орж байгаа юм л даа.

Гантулга: Аа мөн мөн. Дуган хурал гэж нэрнийх нь талаар дуулсан юм байна уу?

Шархүү: Энийг мэдэхгүй юм аа.

Гантулга: Тэр уул усных нь нэрээр нэрлэсэн юм болов уу?

Шархүү: Дуган гэж газар байгаагүй байх. Тэр яагаад тэгж нэрлэсэн юм , ёстой мэдэхгүй юм.

Гантулга: Тэр Хоолтын хурлын тухайд ингээд эрэгэн тойрныг нь яривал?

Шархүү: Хоолтын хурлыг чинь л Маанийн хийд гэж байсан юм шүү дээ.Хоолтын хурлын Маанийн хийдийн баруун талаар бол юу л гэж байдаг юм...Цаад талд нь бол Өлийн нуруу гэж нэг өндөр уул байдаг юм.За тэгээд тэрний талаар Хөх овоо гэж уул нь тахидаг овоо байсан юм гэнэ лээ.

Гантулга: Аа мөн, аль талд нь ?

Шархүү: Зүүн хойд талд нь .За тэгээд баруун талд нь Цогт хайрхан гэж бас нэг хар уул байдаг юм. Тэр Цогтын орой дээр овоо мовоотой л юм байдаг байсан .Бага байхад хонь хариулаад явж байхад. Тэр тахидаг байсан юм уу, үгүй юмуу. Мэдэхгүй. Тэр овоо мовоо оролдож болохгүй гэж л хүмүүс хэлдэг байсан.Тэр хэрэгтэй л газар байсан юм болов уу даа .Хоолт гэдэг чинь өөрөө нэг задгай голтой газар л даа.

Гантулга: Хаагуураа задгай..?

Шархүү: Яг Хоолт дундуураа задгай...

Гантулга: Аан Хоолтын гол гэж?

Шархүү: Хоолтын гол гэж...Тийм л газар байгаа юм .Урдугуураа элстэй.

Гантулга: Таныг бага байхад бол тэр хэлмэгдэлтийн үед лам нарын бурхан тахил ном судрыг нь сүйтгэсэн тийм юм тааралддаг байсан уу, ер нь?

Шархүү: Үгүй ээ үгүй.Ер нь тааралддаггүй байсан.Үгүй байсан шүү.Тэр ном судар гээд бутраад бужигнаад байгаа юм ер нь бага шүү байсан байх шүү. Зүгээр тэр лам эд нар нь байхад тэр дугануудын чинь том том ном

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

ботьнууд бол байдаг байсан ш дээ. Тэгээд л тэр том том номнуудаа улсууд нь үүрээд л явдаг.Их л том том дөрвөлжин номнууд байдаг байсан. Тэр үед нь тэгээд хураагаад авчихдаг байсан юм уу, яадаг байсан юм бүү мэд ээ.

Гантулга: Тэр Дуган хурлын суурин дээр лам нарын хувийн байшин байсан болов уу гэмээр хэдэн шавар байшин гээд байсан ш дээ?

Шархүү: Тийм

Гантулга: Тэр нь одоо юугаар барьсан байх вэ?

Шархүү: Өө дандаа шавраар барьсан.Түүхий шавраар бариад л , түүхий туушийгаар...

Гантулга: Энэ ер нь түүхий тоосгоор барьсан юмнууд их тааралдах юм.Энэ барилга барих нутгийн заншил байна уу, эсвэл тэр хятадын урлаачид тэгж?

Шархүү: Үгүй энэ Монголын өөрийн нь л нутгийн гайгүй материал гэдэг нь тэр байж л дээ.

Гантулга: Аан эндээ хийдэг материал нь ?

Шархүү: Тийм, эндээ хийдэг материал нь .Тэр шавар цохиод л , тууший цохиод л. Тэгээд л шавраа зуураад л хэвэнд цохиод л тэгээд байшин барьдаг.

Гантулга:Хатаагаад л байшингаа барьдаг?

Шархүү: Хатаагаад л барьдаг.

Гантулга: Тэгээд шавраар нь дахиж шаваад л ?

Шархүү: Тийм, тэгээд шавраар нь дахиж шаваад л.

Гантулга: Гадуур нь ингээд өнгөлгөө мөнгөлгөөний юм хийх үү?

Шархүү: Өө ер нь байхгүй шүү дээ.

Гантулга: Зүгээр л шавар л ?

Шархүү: Зүгээр л бор шавар л байшин байдаг байсан. Тийм л түүхтэй юм.

Гантулга: Тэр хийдийн туурин дээгүүр одоо энэ хийдийн барилга байшингийн оройны чимэглэл юм уу, ханын туурганы чимэглэл тийм тоосго моосго...?

Шархүү: Аа тийм мод чулуу одоо юу ч байхгүй ерөөсөө...

Гантулга: Ерөөсөө тэгээд бүр идэгдсэн?

Шархүү: Бүр идэгдсэн, одоо энэ чинь нэг овойсон шавар л хэвтэж байгаагаас өөр юм байхгүй.

Гантулга: Тэр Дуганы хурал , наад Хоолтын хурал...?

Шархүү: Хоолтын Маанийн хийдийг чинь одоо нэг ажигласан хүнд л шавар байшин байж байдаг юм уу гэсэн томъёо л байхаас биш тийм юм байна гэж байхгүй. Дуганы голынх л нэг ахиухан шавар байж байдаг юм, хуучин шавар байсан юм , тэрүүгээрээ л байгаа байх.

Гантулга: Энэ одоо хуучин засаг захиргааныхаа нэгжээр бол аль аймгийн аль хошууны гэж явдаг байсан бэ?

Таныг бага байхад?

Шархүү: Энэ Булантын хошуу гэж явдаг байсан юм болов уу.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гантулга: Тэгээд эргэн тойрны нь ингээд яривал? Тэгж залгадаг, тэгж хиллэдэг гээд?

Шархүү: За мэдэхгүй ээ.

Гантулга: Тэрийг нь мэдэхгүй юу. За танд баярлалаа.

Шархүү: За баярлалаа.